



**САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН  
ХОРШООДЫН  
2022 ОНЫ ХОЁРДУГААР  
УЛИРЛЫН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН  
ТАНИЛЦУУЛГА**

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГАЗАР**

**УЛААНБААТАР ХОТ**

# АГУУЛГА

<b>НЭГ.САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ</b> .....	2
1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл.....	3
1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл.....	4
1.4 Бодлого, зохицуулалтын орчин.....	5
<b>ХОЁР.НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b> .....	6
2.1 Статистик үзүүлэлтүүд.....	6
2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд.....	8
2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	9
2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд.....	10
<b>ГУРАВ.НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	10
3.1 Хөрөнгийн бүтцийн талаар.....	10
3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар.....	12
3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар.....	12
3.4 Зээлийн чанарын талаар.....	12
<b>ДӨРӨВ.НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА</b> .....	14
4.1 Эх үүсвэрийн бүтцийн талаар.....	14
4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар.....	15
4.3 Бусдаас авсан зээл, өр төлбөрийн талаар.....	15
4.4 Бусад богино хугацаат өр төлбөрийн талаар.....	16
4.5 Гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн талаар.....	17
4.6 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар.....	17
<b>ТАВ.ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГАА</b> .....	17
5.1 ХЗХ-дын орлогын талаар.....	17
5.2 ХЗХ-дын зардлын талаар.....	18
5.3 ХЗХ-дын ашигт ажиллагааны талаар.....	18
<b>ЗУРГАА.ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</b> .....	19
6.1 ХЗХ-дын шалгуур үзүүлэлтийн талаар.....	19
<b>ДОЛОО.ДҮГНЭЛТ</b> .....	20

# ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2022 ОНЫ 2 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2022.08.11


Улаанбаатар хот

## НЭГ. САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 1.1 Зах зээлийн ерөнхий мэдээлэл

2022 оны 2 дугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 200 хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх) үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34 ХЗХ буюу 14.5 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант улиралд нийт ХЗХ-дын 45.0 хувь буюу 90 ХЗХ орон нутагт, 55.0 хувь буюу 110 ХЗХ Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулсан байна.

График 1: ХЗХ-дын тоо /хот, орон нутгаар/




Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 24 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 7 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн 28 ХЗХ-ны 294 сонгуульт гишүүн, 20 гүйцэтгэх захирал, 15 нягтлан бодогч, 2 ХЗХ-ны ажлын байрны хаягийн өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгэсэн байна.

Хүснэгт 1: ХЗХ-дын тусгай зөвшөөрлийн мэдээлэл

Он	2018	2019	2020	2021	2022.И
ХЗХ-дын тоо	279	261	249	209	200
Шинээр олгосон	18	17	14	-	5
Хүчингүй болгосон	29	35	26	40	14
Түдгэлзүүлсэн	19	10	23	12	7
Сэргээсэн	7	1	6	1	3
ТЗ-ийн хугацаа сунгасан	100	52	49	85	29

Зураг 1: ХЗХ-дын эрхэлж буй үйл ажиллагаа




## 1.2 ХЗХ-дын тархалтын мэдээлэл

2022 оны 2 дугаар улирлын байдлаар 200 ХЗХ-ны 688 ажилтан, 72,566 гишүүн /72,351 иргэн, 215 хуулийн этгээд/-тэйгээр Монгол Улсын 21 аймаг, 8 дүүрэгт үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 8 дүүрэгт 110 ХЗХ үйл ажиллагаа явуулж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26 ХЗХ буюу 19.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хамгийн их төвлөрөлтэй байна.

Зураг 2: Улаанбаатар хотын ХЗХ-дын тархалт



Орон нутагт Сэлэнгэ аймгаас бусад 20 аймагт 90 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна. Баян-Өлгий, Увс, Говь-Алтай, Ховд, Дорнод аймгуудад төвлөрөл их байгаа бол Булган, Говьсүмбэр, Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий аймагт тус бүр 1 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 3: ХЗХ-дын тархалт



Тайлант улирлын байдлаар нийт 200 ХЗХ 63 салбартайгаар үйл ажиллагаа эрхэлж байна.

Салбарын тархалтын хувьд 4 ХЗХ-ны 7 салбар Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж, 4 ХЗХ-ны 56 салбар орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Үүнд “Гялс төгрөг” ХЗХ-ны 52 салбар Баян-Өлгий аймгаас бусад 19 аймагт тархалттай байна.

График 2: “Гялс төгрөг” ХЗХ-ны салбарын тархалт



### 1.3 ХЗХ-дын гишүүдийн мэдээлэл


2022 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-дын нийт гишүүдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,153 гишүүн буюу 1.56 хувиар буурч 72,566-д хүрсэн үзүүлэлттэй байна. Нийт гишүүдийн 0.3 хувь буюу 215 хуулийн этгээд, 54.4 хувь буюу 39,503 эмэгтэй гишүүн байна.

Зураг 4: ХЗХ-ны гишүүдийн мэдээлэл



Нийт гишүүдийн 56.3 хувь буюу 40,830 гишүүн Улаанбаатар хотод бүртгэлтэй бол 43.7 хувь буюу 31,736 гишүүн орон нутагт бүртгэлтэй байна.

График 3: ХЗХ-дын тоо болон гишүүдийн өөрчлөлт /хот, орон нутгаар/



Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗХ-дын тоо буурч, 2018-2021 оны 2 улирлын байдлаар гишүүдийн тоо тогтмол өсч байсан хэдий ч тайлант хугацаанд 1.56 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХ-дын нийт гишүүдийн 7.5 хувь буюу 5,437 гишүүн “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд байгуулагдсан 51 ХЗХ-ны гишүүд байна.

Мөн тайлант улиралд “Ногоон алт малын эрүүл мэнд төсөл”-ийн санхүүжилттэй 28 ХЗХ 10,955 гишүүнтэй үйл ажиллагаа явуулсан байна.


Нийт 200 ХЗХ-ны 36.5 хувь буюу 73 ХЗХ 20-100 гишүүнтэй, 49.0 хувь буюу 98 ХЗХ 101-500 гишүүнтэй, 10.0 хувь буюу 20 ХЗХ 501-1,000 гишүүнтэй, 4.5 хувь буюу 9 ХЗХ 1,001-ээс дээш гишүүнтэй байна.

Гишүүдийн төвлөрлийг хүснэгтээр харуулбал 1,001-ээс дээш гишүүнтэй 9 ХЗХ-ны гишүүд нийт гишүүдийн 46.2 хувийг эзэлж байна.

Хүснэгт 2: ХЗХ-ны гишүүнчлэл, интервалаар

Гишүүд /интервалаар/	ХЗХ-ны тоо	Гишүүд	Эзлэх хувь
20-100 гишүүнтэй	73	4,181	5.8%
101-500 гишүүнтэй	98	20,514	28.3%
501-1,000 гишүүнтэй	20	14,314	19.7%
1,001-ээс дээш гишүүнтэй	9	33,557	46.2%
<b>Нийт</b>	<b>200</b>	<b>72,566</b>	<b>100.0%</b>

График 4: ХЗХ-ны гишүүдийн төвлөрөл



## 1.4 Бодлого, зохицуулалтын орчин

Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

- Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл”-ийн баримт бичигт тусгагдсаны дагуу Ажлын албаны 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/20 дугаар тушаалаар Орхон, Дархан-Уул аймгуудад үйл ажиллагаа явуулдаг ХЗХ-дыг хамруулан “ХЗХ-ны эрсдэлийн удирдлага” сэдэвт сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 24-ний өдрөөс 29-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус төслийн олон улсын болон үндэсний зөвлөхөд 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Хадгаламж, зээлийн хоршоодын эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд 47 ХЗХ-ны сүүлийн 8 улирлын санхүүгийн тайланд тулгуурлан гаргасан эрсдэлийн үнэлгээний үр дүнг, 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, 2022 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийг шинэчлэн батлах төслийг тус тус танилцуулж, хэлэлцүүлэг хийсэн.

Хууль, эрх зүйн орчин

- Хорооны 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 1/1531 тоот албан бичгээр УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэнд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд

заасан бүрдэл баримт бичгүүдийн хамт хүргүүлсэн.

- Хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлах "ХЗХ-ны активыг ангилах, эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-ын төсөлд санал авахаар 2022 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн 1/2427 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн.
- Хорооны Ажлын албаны даргын 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн А/19 дугаар тушаалаар Хадгаламж, зээлийн хоршоодыг зээлийн батлан даалтын сангийн үйлчилгээнд хамруулах, хоршооны гишүүн бичил, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд олгох зээлийг батлан даах боломжийг судлах, боломжит шийдлийг тодорхойлох чиг үүрэг бүхий Хороо, Зээлийн батлан даалтын сан, МХЗХҮХ-ны хамтарсан ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгээс холбогдох хууль эрх зүйн орчин, ХЗХ-дын үйл ажиллагаа, нэр бүхий ХЗХ-дын зээлийн бүтээгдэхүүн, үйл ажиллагааны журам, нэр бүхий 6 ХЗХ-ны сүүлийн 3 жилийн зээлийн үйл ажиллагаа, ХЗХ-дын 40 том зээлдэгчид олгосон зээл, зээлийн барьцаа хөрөнгө зэрэг холбогдох судалгаануудыг хийж, ЗБДС-аас ХЗХ-дтой хамтран ажиллахад учирч болзошгүй эрсдэлийн дүгнэлтийг гаргаж, түүнд үндэслэн хамтран гаргах бүтээгдэхүүний нөхцөл, шаардлагыг боловсруулж, ЗБДС-ийн судалгаанд хамруулах 10 ХЗХ-ны дэлгэрэнгүй бүртгэл, мэдээллийг 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн.

Хурал, семинар, уулзалт

- Монголбанкнаас зохион байгуулсан ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хэсгийн уулзалтад 2022 оны 5 дугаар сарын 03-ны өдөр цахимаар оролцсон.
- Монголбанкнаас ЗМС-ийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан "Титан Си Ар Эй ЗМС" ХХК-ийн Сайнскор зээлийн мэдээллийн үйлчилгээг ХЗХ-дод танилцуулах цахим уулзалтад 2022 оны 5 дугаар сарын 05-ны өдөр цахимаар оролцсон.
- 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдөр EBRD-аас Монгол Улсад хэрэгжүүлж буй "Төв азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд төсөл"-ийн хүрээнд ажиллаж буй гадаад зөвлөхүүдтэй ЗЗСХГ, ББСБГ-ын төлөөллийн хамт уулзаж, Хорооноос гаргадаг статистик мэдээлэл болон жендерт суурилсан мэдээллийн талаар санал солилцсон. ХЗХ-ны мастерфайлд нэмэх хүйсээр ангилсан зээл болон хадгаламжийн судалгааны хүснэгтийг бэлтгэсэн.
- ХЗХ-ны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлахтай холбоотой асуудлаар 2022 оны 5 дугаар сарын 13-ны өдөр УИХ-ын гишүүн Д.Тогтохсүрэн, Сангийн яамны СЗЗДХ-ийн дарга Л.Сонор, ХДК-ийн гүйцэтгэх захирал Б.Баатарсүрэн, МХЗХҮХ-ны удирдлагууд, АХБ-ны төслийн зөвлөхүүд тус тус хамтран уулзалт зохион байгуулж, харилцан санал солилцсон.
- Монголбанкны ерөнхийлөгчийн 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А-127 дугаар ажлын хэсэг байгуулах тухай тушаалаар Банк, эрх бүхий байгууллагын мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасан зээл, хадгаламжийн хүүгийн аргачлал, мэдээллийн ил тод байдлын тухай журам боловсруулах ажлын хэсэгт газрын төлөөлөл ажиллаж байна.

## ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөлтэй 200 ХЗХ-оос 2022 оны 2 дугаар улирлын тайлангийн нэгтгэлд 14 ХЗХ өмнөх улирлын тайлангаар хамрагдсан.

### 2.1 Статистик үзүүлэлтүүд

Хүснэгт 3: ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд


Статистик мэдээлэл	ХЗХ-ны нийт гишүүд		Үүнээс:			
			Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>200</b>	<b>100.0%</b>	<b>110</b>	<b>55.0%</b>	<b>90</b>	<b>45.0%</b>
<b>Нийт гишүүдийн тоо</b>	<b>72,566</b>	<b>100.0%</b>	<b>40,830</b>	<b>56.3%</b>	<b>31,736</b>	<b>43.7%</b>
Эрэгтэй	32,848	45.3%	16,848	51.3%	16,000	48.7%
Эмэгтэй	39,503	54.4%	23,837	60.3%	15,666	39.7%
Гишүүн хуулийн этгээд	215	0.3%	145	67.4%	70	32.6%
<b>Гишүүдийн насжилт</b>	<b>72,351</b>	<b>100.0%</b>	<b>40,685</b>	<b>56.2%</b>	<b>31,666</b>	<b>43.8%</b>
18-35 насны	20,131	27.8%	11,797	58.6%	8,334	41.4%
36-45 насны	21,685	30.0%	12,885	59.4%	8,800	40.6%
46-55 насны	17,457	24.1%	9,062	51.9%	8,395	48.1%
55-аас дээш	13,078	18.1%	6,941	53.1%	6,137	46.9%
<b>Гишүүдийн боловсрол</b>	<b>72,351</b>	<b>100.0%</b>	<b>40,685</b>	<b>56.2%</b>	<b>31,666</b>	<b>43.8%</b>
Дээд	30,538	42.2%	21,113	69.1%	9,425	30.9%
Тусгай дунд	12,271	17.0%	7,595	61.9%	4,676	38.1%
Бүрэн дунд	20,212	27.9%	10,853	53.7%	9,359	46.3%
Дунд	6,444	8.9%	959	14.9%	5,485	85.1%

Бага	2,886	4.0%	165	5.7%	2721	94.3%
<b>Нийт ажилтнуудын тоо</b>	<b>688</b>	<b>100.0%</b>	<b>399</b>	<b>58.0%</b>	<b>289</b>	<b>42.0%</b>
Үүнээс: эмэгтэй	490	71.2%	297	60.6%	193	39.4%
<b>Санхүүгийн програмтай</b>	<b>99</b>	<b>49.5%</b>	<b>41</b>	<b>20.5%</b>	<b>58</b>	<b>29.0%</b>

ХЗХ-дын нийт гишүүдийн 57.8 хувийг 18-45 насныхан эзэлж байна. Гишүүдийн насжилтыг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс харьцангуй залуу байна.


Нийт гишүүдийн 42.2 хувь нь дээд боловсрол эзэмшсэн байна. Гишүүдийн боловсролын түвшинг хот, орон нутгаар харьцуулахад Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин орон нутгийн ХЗХ-дын гишүүдээс өндөр буюу дээд боловсролтой нийт гишүүдийн 69.1 хувь нь Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд байна.

График 5: ХЗХ-ны гишүүдийн насжилт, УБ, орон нутгаар



- Орон нутаг дахь ХЗХ-дын гишүүдийн насжилт
- Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн насжилт

График 6: ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин, УБ, орон нутгаар



- Орон нутаг дахь ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин
- Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүдийн боловсролын түвшин

Хүснэгт 4: ХЗХ-дын зээлдэгчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт зээлдэгч		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
<b>ХЗХ-дын тоо</b>	<b>200</b>	<b>100.0%</b>	<b>110</b>	<b>55.0%</b>	<b>90</b>	<b>45.0%</b>
<b>Нийт зээлийн үлдэгдэл</b>	<b>217,806,546.33</b>	<b>100.0%</b>	<b>171,157,573.55</b>	<b>78.6%</b>	<b>46,648,972.78</b>	<b>21.4%</b>
<b>Нийт зээлдэгчийн тоо</b>	<b>34,185</b>	<b>100.0%</b>	<b>17,899</b>	<b>52.4%</b>	<b>16,286</b>	<b>47.6%</b>
Иргэн	34,074	99.7%	17,802	99.5%	16,272	99.9%
Эмэгтэй	20,062	58.7%	11,348	63.4%	8,714	53.5%
Хуулийн этгээд	111	0.3%	97	0.5%	14	0.1%
<b>Зээлдэгдийн насжилт</b>	<b>34,074</b>	<b>100.0%</b>	<b>17,802</b>	<b>52.2%</b>	<b>16,272</b>	<b>47.8%</b>
18-35 насны	9,039	26.5%	5,142	28.9%	3,897	23.9%
36-45 насны	10,778	31.6%	6,168	34.6%	4,610	28.3%
46-55 насны	9,555	28.0%	5,190	29.2%	4,365	26.8%
55-аас дээш	4,702	13.8%	1,302	7.3%	3,400	20.9%
<b>Зээлдэгчдийн боловсрол</b>	<b>34,074</b>	<b>100.0%</b>	<b>17,802</b>	<b>52.2%</b>	<b>16,272</b>	<b>47.8%</b>
Дээд	12,554	36.8%	7,502	42.1%	5,052	31.0%
Тусгай дунд	7,726	22.7%	4,753	26.7%	2,973	18.3%
Бүрэн дунд	7,668	22.5%	2,878	16.2%	4,790	29.4%
Дунд	4,826	14.2%	2,588	14.5%	2,238	13.8%
Бага	1,300	3.8%	81	0.5%	1,219	7.5%

Тайлант улиралд ХЗХ-д 34,185 зээлдэгчийн 217,806,546.33 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нийт зээлдэгчийн 52.4 хувь буюу 17,899 зээлдэгч Улаанбаатар

хотын ХЗХ-дын гишүүд ба нийт зээлийн 78.6 хувь буюу 171,157,573.55 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 47.6 хувь буюу 16,286 зээлдэгч орон нутгийн ХЗХ-

дын гишүүд ба нийт зээлийн 21.4 хувь буюу 46,648,972.78 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт зээлдэгчийн 99.7 хувь буюу 34,074 нь хувь хүн (58.7 хувь буюу 20,062 нь эмэгтэй), 0.3 хувь буюу 111 нь хуулийн этгээд байна.

Нэг зээлдэгчид ногдох дундаж зээл 6,371.41 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 9,562.41 мянган төгрөг, орон нутагт 2,864.36 мянган төгрөг байна.

Хүснэгт 5: ХЗХ-дын хадгаламж эзэмшигчдийн статистик үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Статистик мэдээлэл	ХЗХ-дын нийт хадгаламж эзэмшигч		Үүнээс:			
	Тоо	Хувь	Улаанбаатар хот		Орон нутаг	
ХЗХ-дын тоо	200	100.0%	110	55.0%	90	45.0%
<b>Нийт хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>189,373,298.77</b>	<b>100.0%</b>	<b>152,006,827.92</b>	<b>80.3%</b>	<b>37,366,470.85</b>	<b>19.7%</b>
Нийт хадгаламж эзэмшигчийн тоо	37,860	100.0%	19,234	50.8%	18,626	49.2%
Эмэгтэй	20,323	53.7%	10,316	53.6%	10,007	53.7%
<b>Хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>3,296,226.99</b>	<b>1.7%</b>	<b>2,759,287.41</b>	<b>1.8%</b>	<b>536,939.58</b>	<b>1.4%</b>
Хугацаагүй хадгаламж эзэмшигчийн тоо	3,813	10.1%	2,638	13.7%	1,175	6.3%
Иргэн	3,793	10.0%	2,620	13.6%	1,173	6.3%
Хуулийн этгээд	20	0.1%	18	0.1%	2	0.0%
<b>Хугацаатай хадгаламжийн үлдэгдэл</b>	<b>186,077,071.78</b>	<b>98.3%</b>	<b>149,247,540.51</b>	<b>98.2%</b>	<b>36,829,531.27</b>	<b>98.6%</b>
Хугацаатай хадгаламж эзэмшигчийн тоо	34,047	89.9%	16,596	86.3%	17,451	93.7%
Иргэн	33,991	89.8%	16,574	86.2%	17,417	93.5%
Хуулийн этгээд	56	0.1%	22	0.1%	34	0.2%
<b>Хадгаламж эзэмшигчдийн насжилт</b>	<b>37,784</b>	<b>100.0%</b>	<b>19,194</b>	<b>50.8%</b>	<b>18,590</b>	<b>49.2%</b>
18-35 насны	13,076	34.6%	7,685	40.0%	5,391	29.0%
36-45 насны	10,132	26.8%	4,934	25.7%	5,198	28.0%
46-55 насны	8,262	21.9%	3,857	20.1%	4,405	23.7%
55-аас дээш	6,314	16.7%	2,718	14.2%	3,596	19.3%
<b>Хадгаламж эзэмшигчдийн боловсрол</b>	<b>37,784</b>	<b>100.0%</b>	<b>19,194</b>	<b>50.8%</b>	<b>18,590</b>	<b>49.2%</b>
Дээд	17,881	47.3%	12,380	64.5%	5,501	29.6%
Тусгай дунд	5,327	14.1%	2,262	11.8%	3,065	16.5%
Бүрэн дунд	8,377	22.2%	3,254	17.0%	5,123	27.6%
Дунд	4,023	10.6%	829	4.3%	3,194	17.2%
Бага	2,176	5.8%	469	2.4%	1,707	9.2%

2022 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-д 37,860 хадгаламж эзэмшигчийн 189,373,298.77 мянган төгрөгийн хадгаламжийг татан төвлөрүүлсэн байна. Нийт хадгаламж эзэмшигчийн 50.8 хувь буюу 19,234 хадгаламж эзэмшигч Улаанбаатар хотын ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 80.3 хувь буюу 152,006,827.92 мянган төгрөгийг бүрдүүлж байна. Харин 49.2 хувь буюу 18,626 хадгаламж эзэмшигч нь орон нутгийн ХЗХ-дын гишүүд ба нийт хадгаламжийн 19.7 хувь буюу 37,366,470.85 мянган төгрөгийг бүрдүүлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 10.1 хувийг хугацаагүй, 89.9 хувийг хугацаатай хадгаламжтай гишүүд эзэлж байна.

Нийт хадгаламж эзэмшигчийн 99.8 хувь буюу 37,784 нь хувь хүн (53.8 хувь буюу 20,323 нь эмэгтэй), 0.2 хувь буюу 76 нь хуулийн этгээд байна.

Нэг хадгаламж, эзэмшигчид ногдох дундаж хадгаламж 5,001.94 мянган төгрөг байгаа бөгөөд тус үзүүлэлт Улаанбаатар хотод 7,903.03 мянган төгрөг, орон нутагт 2,006.15 мянган төгрөг байна.

## 2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

2022 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 271,603,553.57 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 хувь буюу 1,128,081.37 мянган төгрөгөөр өсөж банкны зах зээлийн 0.6 хувьтай тэнцэж байна.

Тайлант улиралд нийт зээлийн үлдэгдэл 16.6 хувь буюу 30,991,678.05 мянган төгрөгөөр өсч, нийт татан төвлөрүүлсэн

хадгаламж 0.9 хувь буюу 1,790,917.73 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт орлого 7.9 хувь буюу 2,199,141.86 мянган төгрөг, нийт зарлага 10.3 хувь буюу 2,337,036.79 мянган төгрөгөөр тус тус өсч, нийт цэвэр орлого 2.7 хувь буюу 137,894.93 мянган төгрөгөөр буурч 5,033,480.86 мянган төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 6: ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны II улирал	2022 оны II улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт хөрөнгө</b>	270,475,472.20	271,603,553.57		
Банкны салбарт эзлэх хувь	0.7%	0.6%	1,128,081.37	0.4%
<b>Нийт зээл</b>	186,814,868.28	217,806,546.33		
Банкны салбарт эзлэх хувь	1.0%	0.9%	30,991,678.05	16.6%
<b>Нийт чанаргүй зээл</b>	6,923,746.89	7,249,010.30		
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	3.7%	3.3%	325,263.41	4.7%
Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.3%	-0.4%	-10.2%
			0.0%	-3.4%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	191,164,216.50	189,373,298.77		
Банкны салбарт эзлэх хувь	1.0%	1.1%	-1,790,917.73	-0.9%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	22,593,048.55	26,070,166.34		
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	33,023,401.87	27,247,815.41		
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	6,615,725.14	3,572,483.26		
Нийт орлого	27,875,522.52	30,074,664.38	3,477,117.79	15.4%
Нийт зарлага	22,704,146.73	25,041,183.52	-5,775,586.46	-17.5%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>5,171,375.79</b>	<b>5,033,480.86</b>	<b>-137,894.93</b>	<b>-2.7%</b>

### 2.2.1 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 110 ХЗХ-ны нийт хөрөнгө 216,312,844.09 мянган төгрөг нь зах зээлийн 79.6 хувь, нийт зээл 171,157,573.55 мянган төгрөг нь зах зээлийн 78.6 хувь, нийт хадгаламж 152,006,827.92 мянган төгрөг нь зах зээлийн 80.3 хувийг тус тус бүрдүүлж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.0 хувь буюу 121,121.00 мянган төгрөгөөр өсч 6,286,514.08 мянган төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 3.7 хувийг эзэлж байна. Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс

авсан зээл өмнөх оны мөн үеэс 45.8 хувь буюу 2,989,564.70 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 1.4 хувь буюу 310,397.12 мянган төгрөгөөр, нийт зарлага 5.7 хувь буюу 1,030,154.58 мянган төгрөгөөр өсч, нийт цэвэр орлого 17.5 хувь буюу 719,757.46 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу Улаанбаатар хотын 77 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 7: Улаанбаатар хотын ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны II улирал	2022 оны II улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт хөрөнгө</b>	224,641,124.16	216,312,844.09	-8,328,280.07	-3.7%
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	83.1%	79.6%	-3.4%	-4.1%
<b>Нийт зээл</b>	152,332,002.71	171,157,573.55	18,825,570.84	12.4%
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	81.5%	78.6%	-3.0%	-3.6%
<b>Нийт чанаргүй зээл</b>	6,165,393.08	6,286,514.08	121,121.00	2.0%

ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	89.0%	86.7%	-2.3%	-2.6%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	4.0%	3.7%	-0.4%	-9.3%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	159,917,334.25	152,006,827.92	-7,910,506.33	-4.9%
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	83.7%	80.3%	-3.4%	-4.0%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	16,507,679.66	19,563,325.98	3,055,646.32	18.5%
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	73.1%	75.0%	2.0%	2.7%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	27,013,092.56	19,183,747.52	-7,829,345.04	-29.0%
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	81.8%	70.4%	-11.4%	-13.9%
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	6,525,947.96	3,536,383.26	-2,989,564.70	-45.8%
Нийт орлого	22,193,829.89	22,504,227.01	310,397.12	1.4%
Нийт зарлага	18,083,785.52	19,113,940.10	1,030,154.58	5.7%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>4,110,044.37</b>	<b>3,390,286.91</b>	<b>-719,757.46</b>	<b>-17.5%</b>

## 2.2.2 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 90 ХЗХ-ны нийт хөрөнгө 55,290,709.48 мянган төгрөг нь зах зээлийн 20.4 хувь, нийт зээлийн үлдэгдэл 46,648,972.78 мянган төгрөг нь зах зээлийн 21.4 хувь, нийт хадгаламж 37,366,470.85 мянган төгрөг нь зах зээлийн 19.7 хувийг тус тус эзэлж байна. Нийт орлого өмнөх оны мөн үеэс 33.2 хувь буюу 1,888,744.74 мянган төгрөг, нийт

зарлага 28.3 хувь буюу 1,306,882.21 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, цэвэр орлого 54.8 хувь буюу 581,862.53 мянган төгрөгөөр өсч 1,643,193.95 мянган төгрөгт хүрсэн байна.

Зээлийн мэдээллийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн 31 ХЗХ “Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээ”-г байгуулсан байна.

Хүснэгт 8: Орон нутгийн ХЗХ-дын санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/

Үндсэн үзүүлэлтүүд	2021 оны II улирал	2022 оны II улирал	Өөрчлөлт	
			дүн	хувь
<b>Нийт хөрөнгө</b>	<b>45,834,348.05</b>	<b>55,290,709.48</b>	<b>9,456,361.43</b>	<b>20.6%</b>
ХЗХ-ны нийт хөрөнгөд эзлэх хувь	16.9%	20.4%	3.4%	20.1%
<b>Нийт зээл</b>	<b>34,482,865.57</b>	<b>46,648,972.78</b>	<b>12,166,107.21</b>	<b>35.3%</b>
ХЗХ-ны нийт зээлд эзлэх хувь	18.5%	21.4%	3.0%	16.0%
<b>Нийт чанаргүй зээл</b>	<b>758,353.81</b>	<b>962,496.22</b>	<b>204,142.41</b>	<b>26.9%</b>
ХЗХ-ны нийт чанаргүй зээлд эзлэх хувь	11.0%	13.3%	2.3%	21.2%
Нийт зээлд чанаргүй зээлийн эзлэх хувь	0.5%	0.6%	0.1%	13.0%
<b>Нийт татан төвлөрүүлсэн хадгаламж</b>	<b>31,246,882.25</b>	<b>37,366,470.85</b>	<b>6,119,588.60</b>	<b>19.6%</b>
ХЗХ-ны нийт хадгаламжид эзлэх хувь	16.3%	19.7%	3.4%	20.7%
<b>Нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгө</b>	<b>6,085,368.90</b>	<b>6,506,840.36</b>	<b>421,471.46</b>	<b>6.9%</b>
ХЗХ-ны нийт гишүүдийн оруулсан хувь хөрөнгөд эзлэх хувь	26.9%	25.0%	-2.0%	-7.3%
<b>Нийт хоршоологчдын өмч</b>	<b>6,010,309.31</b>	<b>8,064,067.89</b>	<b>2,053,758.58</b>	<b>34.2%</b>
ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчид эзлэх хувь	18.2%	29.6%	11.4%	62.6%
<b>Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээл</b>	<b>89,777.18</b>	<b>36,100.00</b>	<b>-53,677.18</b>	<b>-59.8%</b>
Нийт орлого	5,681,692.63	7,570,437.37	1,888,744.74	33.2%
Нийт зарлага	4,620,361.21	5,927,243.42	1,306,882.21	28.3%
<b>Цэвэр орлого, алдагдал</b>	<b>1,061,331.42</b>	<b>1,643,193.95</b>	<b>581,862.53</b>	<b>54.8%</b>

## ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


### 3.1 Хөрөнгийн бүтцийн талаар

Хүснэгт 9: ХЗХ-дын хөрөнгийн бүтэц /мянган төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	2021 оны II улирал		2022 оны II улирал		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>262,164,699.33</b>	<b>96.9%</b>	<b>267,695,313.26</b>	<b>98.6%</b>	<b>5,530,613.93</b>	<b>2.1%</b>
<b>Мөнгөн хөрөнгө</b>	69,431,704.31	25.7%	35,233,081.06	13.0%	-34,198,623.25	-49.3%
Бэлэн мөнгө	4,262,483.59	1.6%	5,336,562.89	2.0%	1,074,079.30	25.2%
Банкинд байршуулсан харилцах	18,220,772.64	6.7%	7,100,360.98	2.6%	-11,120,411.66	-61.0%
Банкинд байршуулсан хадгаламж	46,948,448.07	17.4%	22,796,157.19	8.4%	-24,152,290.88	-51.4%
<b>Богино хугацаат хөрөнгө оруулалт</b>	<b>150,000.00</b>	<b>0.1%</b>	<b>220,000.00</b>	<b>0.1%</b>	<b>70,000.00</b>	<b>46.7%</b>

Арилжааны үнэт цаас	150,000.00	0.1%	220,000.00	0.1%	70,000.00	46.7%
<b>Зээл /цэврээр/</b>	<b>181,775,548.93</b>	<b>67.2%</b>	<b>212,174,169.57</b>	<b>78.1%</b>	<b>30,398,620.64</b>	<b>16.7%</b>
Нийт зээл	186,814,868.28	69.1%	217,806,546.33	80.2%	30,991,678.05	16.6%
Хэвийн зээл	174,783,271.82	64.6%	204,939,114.82	75.5%	30,155,843.00	17.3%
Хугацаа хэтгэрсэн зээл	5,107,849.57	1.9%	5,618,421.20	2.1%	510,571.63	10.0%
Чанаргүй зээл	6,923,746.89	2.6%	7,249,010.31	2.7%	325,263.42	4.7%
(Зээлийн эрсдэлийн сан)	5,039,319.35	1.9%	5,632,376.76	2.1%	593,057.41	11.8%
<b>Авлага</b>	<b>9,087,523.25</b>	<b>3.4%</b>	<b>17,841,987.37</b>	<b>6.6%</b>	<b>8,754,464.12</b>	<b>96.3%</b>
Байгууллага, хүмүүсээс авах авлага	875,761.64	0.3%	9,751,542.38	3.6%	8,875,780.74	1013.5%
Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	8,211,761.62	3.0%	8,090,444.99	3.0%	-121,316.63	-1.5%
<b>Бусад эргэлтийн хөрөнгө</b>	<b>999,815.38</b>	<b>0.4%</b>	<b>1,286,158.61</b>	<b>0.5%</b>	<b>286,343.23</b>	<b>28.6%</b>
<b>Өмчлөх бусад хөрөнгө /цэвэр/</b>	<b>720,107.46</b>	<b>0.3%</b>	<b>939,916.65</b>	<b>0.3%</b>	<b>219,809.19</b>	<b>30.5%</b>
Өмчлөх бусад хөрөнгө	726,185.81	0.3%	978,229.97	0.4%	252,044.16	34.7%
(Өмчлөх бусад хөрөнгийн хасагдуулга)	6,078.35	0.0%	38,313.32	0.0%	32,234.97	530.3%
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>8,310,772.88</b>	<b>3.1%</b>	<b>3,908,240.31</b>	<b>1.4%</b>	<b>-4,402,532.57</b>	<b>-53.0%</b>
<b>Үндсэн хөрөнгө /цэвэр/</b>	<b>4,175,154.12</b>	<b>1.5%</b>	<b>3,666,767.85</b>	<b>1.4%</b>	<b>-508,386.27</b>	<b>-12.2%</b>
Үндсэн хөрөнгө	6,062,336.30	2.2%	5,831,208.63	2.1%	-231,127.67	-3.8%
(Хуримтлагдсан элэгдэл)	1,887,182.18	0.7%	2,164,440.78	0.8%	277,258.60	14.7%
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>4,120,132.63</b>	<b>1.5%</b>	<b>226,452.46</b>	<b>0.1%</b>	<b>-3,893,680.17</b>	<b>-94.5%</b>
Биет бус хөрөнгө	4,179,559.93	1.5%	321,241.68	0.1%	-3,858,318.25	-92.3%
(Биет бус хөрөнгийн элэгдэл)	59,427.30	0.0%	94,789.23	0.0%	35,361.93	59.5%
<b>Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө</b>	<b>15,486.13</b>	<b>0.0%</b>	<b>15,020.00</b>	<b>0.0%</b>	<b>-466.13</b>	<b>-3.0%</b>
Хөрөнгө оруулалт, бусад хөрөнгө	15,486.13	0.0%	15,020.00	0.0%	-466.13	-3.0%
<b>Хөрөнгийн дүн</b>	<b>270,475,472.20</b>	<b>100.0%</b>	<b>271,603,553.57</b>	<b>100.0%</b>	<b>1,128,081.37</b>	<b>0.4%</b>

Зураг 5: Хөрөнгийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/




2022 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгө 271,603,553.57 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.4 хувь буюу 1,128,081.37 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Зах зээлийн нийт хөрөнгийн 98.6 хувийг эргэлтийн хөрөнгө, 1.4 хувийг эргэлтийн бус хөрөнгө бүрдүүлж байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгийн 13.0 хувийг, цэвэр зээл 78.1 хувийг тус тус эзэлж байна.

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 16.6 хувь буюу 30,991,678.05 мянган төгрөгөөр өсөж 217,806,546.33 мянган

төгрөгт хүрсэн бөгөөд 5,632,376.76 мянган төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 212,174,169.57 мянган төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна. Харин хугацаа хэтгэрсэн зээл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.0 хувь буюу 510,571.63 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

ХЗХ-ны зах зээлийн нийт хөрөнгийн өөрчлөлтийг сүүлийн 5 жилээр харьцуулахад тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тоо буурсан ч хөрөнгийн хэмжээ тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна.

График 7: ХЗХ-дын тоо болон нийт хөрөнгийн өөрчлөлт /тэрбум төгрөгөөр/




### 3.2 Хөрөнгийн төвлөрлийн талаар

ХЗХ-дыг хөрөнгийн хэмжээгээр нь ангилахад 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгөтэй 4 ХЗХ-ны нийт хөрөнгө 162,522,708.42 мянган төгрөг нь зах зээлийн нийт хөрөнгийн 59.8 хувийг, гишүүдийн тоо 21,520 байгаа нь нийт гишүүдийн 29.6 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 10: ХЗХ-дын хөрөнгийн төвлөрөл, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Хөрөнгийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт хөрөнгө		Гишүүд	
			Дүн	Хувь	Тоо	Хувь
1	10,000,000.0-аас дээш	4	162,522,708.42	59.8%	21,520	29.6%
2	1,000,000.0 -10,000,000.0	24	73,936,153.68	27.2%	22,857	31.5%
3	500,000.0-1,000,000.0	20	14,268,327.83	5.3%	8,556	11.8%
4	100,000.0-500,000.0	76	16,422,387.53	6.1%	13,695	18.9%
5	50,000.0-100,000.0	49	3,592,916.55	1.3%	4,293	5.9%
6	10,000.0-50,000.0	25	851,812.43	0.3%	1,599	2.2%
7	10,000.0 хүртэл	2	9,247.13	0.0%	46	0.1%
Нийт дүн		200	271,603,553.57	100.0%	72,566	100.0%



### 3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Тайлант улиралд зах зээл дэх нийт зээлийн үлдэгдэл 217,806,546.33 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 80.2 хувь, цэвэр зээлийн үлдэгдэл 212,174,169.57 мянган төгрөг буюу нийт хөрөнгийн 78.1 хувийг тус тус эзэлж байна.

Зээлийн жигнэсэн дундаж хүү сарын 2.1 хувь байна.

1 тэрбум төгрөгөөс дээш зээлийн үлдэгдэлтэй 24 ХЗХ-ны зээлийн дүн зах зээлийн нийт зээлийн 85.6 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд тайлант улиралд 2022 оны 1 дүгээр сард тусгай зөвшөөрөл олгосон

“Далай хишиг финанс”, 2 дугаар улиралд тусгай зөвшөөрөл олгосон “Юбикаб кредит” ХЗХ зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Хүснэгт 11: ХЗХ-дын зээлийн хэмжээ, интервалаар /мянган төгрөгөөр/

№	Зээлийн хэмжээ	ХЗХ-дын тоо	Зээлийн дүн	Эзлэх хувь
1	1,000,000.0 дээш	24	186,522,095.67	85.6%
2	500,000.0-1,000,000.0	17	11,680,484.34	5.4%
3	100,000.0-500,000.0	65	14,790,772.81	6.8%
4	50,000.0-100,000.0	48	3,478,983.27	1.6%
5	10,000.0-50,000.0	40	1,305,544.19	0.6%
6	10,000.0 хүртэл	4	28,666.04	0.0%
7	Зээлийн үйл ажиллагаа эрхлээгүй	2	-	-
Нийт дүн		200	217,806,546.33	100%

### 3.4 Зээлийн чанарын талаар

Хүснэгт 12: Зээлийн ангиллын мэдээлэл /мянган төгрөгөөр/

Зээлийн ангиллын мэдээлэл	Зээлдэгчийн мэдээлэл		Зээлийн үлдэгдэл		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
<b>Нийт</b>	<b>34,185</b>	<b>100.0%</b>	<b>217,806,546.33</b>	<b>100.0%</b>	
Хэвийн	31,590	92.4%	204,939,114.82	94.1%	
Хугацаа хэтэрсэн	1,199	3.5%	5,618,421.20	2.6%	
Чанаргүй	1,396	4.1%	7,249,010.31	3.3%	
	<i>Хэвийн бус</i>	<i>510</i>	<i>36.5%</i>	<i>1,817,616.50</i>	<i>25.1%</i>
	<i>Эргэлзээтэй</i>	<i>318</i>	<i>22.8%</i>	<i>1,286,779.97</i>	<i>17.7%</i>
	<i>Муу</i>	<i>568</i>	<i>40.7%</i>	<i>4,144,613.83</i>	<i>57.2%</i>


2022 оны 2 дугаар улирлын байдлаар ХЗХ-ны зах зээлийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 94.1 хувь буюу 204,939,114.82 мянган төгрөгийг хэвийн зээл, 2.6 хувь буюу 5,618,421.20 мянган төгрөгийг хугацаа хэтэрсэн зээл, 3.3 хувь

буюу 7,249,010.31 мянган төгрөгийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Тайлант хугацаанд хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 12,867,431.51 мянган төгрөгийн үлдэгдэлд 43.8 хувь буюу 5,632,376.76

мянган төгрөгийн зээлийн эрсдэлийн санг байгуулсан байна.

Зээлдэгчдийн мэдээллийг зээлийн чанараар ангилахад нийт зээлдэгчийн 92.4 хувийг хэвийн, 3.5 хувийг хугацаа хэтэрсэн, 4.1 хувийг чанаргүй зээл эзэлж

График 8: Зээлийн чанар



байна. Чанаргүй зээлийн үлдэгдэлтэй 1,396 зээлдэгчийн 7,249,010.31 мянган төгрөгийн үлдэгдлийн 36.5 хувийг хэвийн бус, 22.8 хувийг эргэлзээтэй, 40.7 хувийг муу зээлийн үлдэгдэлтэй зээлдэгчид тус тус эзэлж байна.

Тайлант улиралд нийт зээлд эзлэх хэвийн зээлийн хувь хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.5 пунктээр өсч 94.1 хувь, хугацаа хэтэрсэн зээлийн хувь хэмжээ 0.1 пунктээр буурч 2.6 хувь, чанаргүй зээлийн хувь хэмжээ 0.4 пунктээр буурч 3.3 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 13: Зээлийн бүтээгдэхүүнээр /мянган төгрөгөөр/

№	ЗЭЭЛИЙН ЗОРИУЛАЛТ	Зээлийн эхний үлдэгдэл /дүн/	Тайлант хугацаанд олгосон зээл	Тайлант хугацаанд эргэн төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл	Зээлийн үлдэгдлийн нийт зээлд эзлэх хувь
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	8,500,251.55	7,551,427.02	7,459,951.91	8,591,726.66	3.9%
2	Уул уурхай, олборлолт	2,117,427.09	1,186,698.12	1,166,228.79	2,137,896.42	1.0%
3	Боловсруулах үйлдвэрлэл	1,602,093.51	1,148,821.26	777,660.81	1,973,253.96	0.9%
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	690,676.94	544,927.65	431,376.70	804,227.89	0.4%
